

БАТЛАВ
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ, ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА
Б.БОЛОР-ЭРДЭНЭ
2026 оны 01 дүгээр сарын 13 өдөр

**ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН АЖИЛТАН, АЛБАН ХААГЧДАД
ШАГНАЛ ОЛГОХ БҮРТГЭЛ, УДРДЛАГЫН ЦАХИМ ПРОГРАММ
БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР**

2026 оны 01 дүгээр сарын 13

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

Монгол улсын Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 24-ний “Цахимаар нэн тэргүүнд(DIGITAL FIRST)” бодлогын зөвлөмж батлах тухай 108 дугаар тогтоол, Зам, тээврийн сайдын 2024 оны а/240 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн салбарын ажилтан, албан хаагчдад шагнал олгох журам”-ыг тус тус үндэслэл болгов.

Хоёр. Зорилго

2.1. Байгууллага, аж ахуй нэгжид цахим үйлчилгээг санал болгож, түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх,

2.2. Зам, тээврийн салбарын шагнал горилогчдын мэдээллийн санг бий болгоно,

2.3. Шагналын мэдээллийн сангийн өгөгдлүүд дээр дата анализ хийж шийдвэр гаргалтын түвшинд ашиглах.

Гурав. Ажлын даалгавар боловсруулах үндэслэл, өнөөгийн нөхцөл байдал

Зам, тээврийн салбарын болон яамны шагналаар шагнуулахаар жилд дунджаар 3500 орчим иргэдийн материалыг цахим программаар PDF хувилбараар хүлээн авч хариу өгч байгаа бөгөөд энэ үйлчилгээг үзүүлэхэд цаг хугацаа ихээхэн зарцуулагдаж байна.

Тухайлбал: Зам, тээврийн сайдын 2024 оны а/240 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн салбарын ажилтан, албан хаагчдад шагнал олгох журам” болон журамд заасан салбарын болон яамны шагнал авахад бүрдүүлэх материалын жагсаалтыг байгууллагын цахим хуудсанд байршуулсан байдаг. Гэтэл байгууллага, аж ахуй нэгжээс шагналд нэр дэвшигчдийн материалыг оруулахдаа материалын бүрдүүлэл дутуу, шаардлага хангахгүй нэр төдий байдлаар ирүүлдэг, цахим программд шагналын шийдвэр гарчихсан байхад шийдэгдсэн эсэх асуудлаар олон дахин асуух /утсаар/ асуудал тогтмол гарч байна.

Хэрэглэгч талаас тухайн программд нэвтрэх нэр нууц үгийг дахин сэргээх холбоос хийгдээгүйгээс нууц үгээ мартсан тохиолдолд заавал утсаар холбогдож сэргээлгэх, засварлах шаардлагатай цэсэд шилжүүлсэн иргэдийн мэдээлэлд засвар хийж буцаан хүсэлтэд шилжүүлэх боломжгүй, оруулсан мэдээлэлд засвар хийхэд алдаа зааж засвар ордоггүй, нэр дэвшигчийн холбогдох мэдээллийг сканердсан зурган файлаар оруулдаг зэрэг нөхцөл байдалтай байна

Иймд материалыг онлайнаар хүлээн авах үйлчилгээг илүү боловсронгуй болгож төрийн мэдээлэл солилцооны “ХУР” систем, танилт нэвтрэлтийн “ДАН” системийг шинээр холбон нэвтрүүлж шагналын өргөдөл шийдэгдсэн талаарх мэдээллийг түргэн шуурхай, харилцагчийн цахим шуудан, гар утсанд илгээх, иргэдэд үйлчлэх систем “e-mongolia.mn”-ийн мэдэгдэл хүргэх системд холбогдох боломж бүхий цахим удирдлагын программ хангамжийг нэвтрүүлэх шаардлагатай байна.

Дөрөв. Шагналын цахим программд хийгдэх ажил

Цахим программ хангамжийн үйлчилгээ нь эрэглэгчдэд хялбар хүртээмжтэй байх бөгөөд захиалагчийн хэрэгцээ шаардлагад бүрэн нийцүүлэн, гэрээнд заасан хугацаанд боловсруулж, нэвтрүүлэх шаардлагатай.

4.1. Цахим программ хангамжийг цахим засаглал үндэсний хөтөлбөр, “Цахимаар нэн тэргүүнд(DIGITAL FIRST)” бодлогын зөвлөмжийн зорилго, зорилт зарчимд тулгуурлан бусад хууль, журамд нийцүүлэн боловсруулах,

4.2. Цахим программд хийгдэх үйлдлүүд, шагналын материалын бүрдлийг шалгах, бүртгэх, үнэлэх, хариу өгөх үйл ажиллагаа нь Зам, тээврийн сайдын 2024 оны а/240 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн салбарын ажилтан, албан хаагчдад шагнал олгох журам”, түүний шинэчилсэн найруулгын дагуу хийгдсэн байх,

4.3. Программ хангамжийг цаашид хөгжүүлэх боломжтой, олон улсын програмчлалын чиг хандлага, үндэсний бодлого чиглэлд нийцсэн технологи ашиглан хөгжүүлэх, материалын бүрдлийг шалгах процесс нь хиймэл оюун ухаанд суурилсан байх,

4.4. Программ хангамжийг бусад программ хангамжтай мэдээллийн сангийн түвшинд холбогдон ажиллах, вэб сервис хөгжүүлэх боломжтой хувилбараар хөгжүүлэх,

4.5. Эйбл системийн шагнал модультай холбогдох боломжтой байх,

4.6. Зам, тээврийн салбарын шагнал олгох үйлчилгээний зохицуулалтын өөрчлөлтөөс үүдэлтэй системд хийгдэх логик үйлдлийн дараалал, программын алгоритм нь өөрчлөгдөх бол хялбар аргаар өөрчлөх боломжтой байх гүйцэтгэгч баталгаат хугацаанд үнэ төлбөргүй өөрчлөлт хийгддэг байх.

Тав. Программ хангамжийн ерөнхий бүтэц

5.1. Шагналын программ хангамж нь эхний байдлаар дараах дэд модуль программаас бүрдсэн байна. Үүнд:

1. Үндсэн нүүр хуудас, нэвтрэх хэсэг
2. Удирдлагын самбар, мэргэжилтний самбар

3. Байгууллага, аж ахуй нэгжийн самбар
4. Статистик үзүүлэлт

Зургаа. Удирдлагын самбар

- 6.1. Удирдлагын самбар нь нэвтрэх нэр, нууц үгээр хамгаалагдсан байна.
- 6.2. Удирдлагын самбарт нэвтрэх эрхтэй мэргэжилтнүүдийг нэмж, хасах боломжтой байна.
- 6.3. Шагналд нэр дэвшигчдийн мэдээллийг илгээх албан байгууллагуудын нэвтрэх эрх олгох, засах, устгах боломжтой байна. (Байгууллагын нэр, регистр, материал илгээгч ажилтны и-мэйл хаяг, гар утасны дугаар, нэвтрэх нууц үг, бусад мэдээлэл)
- 6.4. Албан байгууллагуудын илгээсэн шагналд нэр дэвшигчдийн анкет, хавсралт албан бичиг, файлуудыг огноогоор, албан байгууллагаар нь шүүх, түлхүүр үгээр хайж үзэх, хэвлэх, засах, устгах боломжтой байна.
- 6.5. Систем нь өөрийн чат боттой байх бөгөөд шагналд нэр дэвшигчдийн анкет, хавсралт албан бичиг, файлуудыг харуулах команд өгөхөд түргэн шуурхай гаргаж ирэх, Excel, Word файлаар татаж авах боломжтой байна.
- 6.6. Шагнал хүсэгчдээс ирүүлсэн материалыг систем хүлээн аваад хиймэл оюун ухаан автоматаар хянаж, шаардлага хангасан иргэдийг ялгаж шагнал хариуцсан мэргэжилтэнд эцсийн байдлаар хянах, батлах боломжтой байна.
- 6.7. Албан байгууллагын шагналд нэр дэвшигчдийн мэдээллийг илгээх эрхтэй ажилтны бүртгэлтэй гар утасны дугаар руу шагнал гарсан, материал буцаагдсан талаар мессеж илгээх боломжтой байна.
- 6.8. Систем нь шагналд шалгарсан иргэдийн мэдээлэл, тушаал шийдвэрийн дугаар, үнэмлэхний дугаарлалт зэргийг тооцоолон үнэмлэхний загварт автоматаар оруулан хэвлэхэд бэлэн болгож, хэвлэхэд шаардлагатай өргөтгөлөөр татан авах боломжтой байна.

Долоо. Байгууллага, аж ахуй нэгжийн самбар

- 7.1. Байгууллага, аж ахуй нэгж нь шагналд нэр дэвших эрх олгох хүсэлтээ илгээх боломжтой байна.
- 7.2. Байгууллага, аж ахуй нэгж нь яамнаас олгосон нэвтрэх нэр, нууц үгээр самбарт нэвтэрнэ.
- 7.3. Нэвтрэх нууц үгээ мартсан бол бүртгэлтэй и-мэйл хаягаараа нууц үгээ шинээр авах боломжтой байна.
- 7.4. Байгууллага, аж ахуй нэгж нь нэвтрэх и-мэйл хаяг, нууц үгээ солих шинэчлэх боломжтой байна.
- 7.5. Байгууллага, аж ахуй нэгж нь салбарын шагнал авах хүсэлтээ доорх мэдээллийн дагуу илгээх, засах, устгах боломжтой байна. Шагнал олгогдсон төлөвтэй иргэний мэдээллийг устгах боломжгүй байна.

- Шагналд нэр дэвшүүлсэн тухай байгууллагын албан бичиг (сканердсан файл - заавал)

- Хамт олны эсхүл удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэл (сканердсан файл - заавал)

- Батлагдсан загвар анкетын формыг бөглөх

- Ажил байдлын тодорхойлолтыг тусгай формд бөглөсөн байх. (бүтээлийн жагсаалтыг хавсаргасан тохиолдол сканердсан файлаар оруулах)

- Өмнө шагнагдсан шагналуудын хуулбар (сканердсан файл – заавал биш)

- Нийгмийн даатгал төлөлтийг НД-8 маягтын дагуу “ХУР” системээс шалгана.

- Онцгой амжилт гаргасан бол түүнийг гэрчлэх баримт бичиг, шийдвэрийн хуулбар (сканердсан файл – заавал биш)

7.5. Системийн чатбот нь онлайн туслахын үүргээр ажилладаг байх бөгөөд иргэд, аж ахуйн нэгжээс ирсэн систем ашиглалт, материал бүрдүүлэлттэй холбоотой асуулт, хариултыг цаг алдалгүй өгдөг байна.

Найм. Техникийн шаардлага

8.1. Программ хангамж нь Apache эсвэл Nginx веб сервер дээр ажилладаг байх.

8.2. Өгөгдлийн сан нь MySQL.

8.3. Веб програмчлалын хэл PHP (ямар нэгэн фрэймворк ашиглах)

8.4. Мэдээллийн аюулгүй байдлыг маш сайн хангасан байх

8.4.1. SSL сертификатаар хамгаалагдсан

8.4.2. SQL injection, Session hijack, XSS, File upload vulnerability зэрэг аргуудаас хамгаалагдсан байх

Ёс. Программ хангамжийн интерфэйсийн шаардлага

9.1. Программ хангамжийн интерфэйс нь хэрэглэгчид ашиглахад хялбар буюу user firendly зарчимтай ажиллах.

9.2. Программын дэлгэцийн зохиомж нь энгийн, зохион байгуулалт, эмх цэгцтэй байх.

Арав. Программын мэдээллийг архивлах, мэдээллийн сан үүсгэх

10.1. Улирал, хагас, бүтэн жилээр тайлагнаж, шагнал олгосон, шагнал олгохоос татгалзсан, материал бүрдүүлэлт дахин хийлгэхээр буцсан тухай тайлангууд хадгалагдаж мэдээллийн сан үүсгэнэ.

10.2. Мэдээллийн санг улирал, жил бүр нөөцлөн хэрэгтэй үед ямар ч утга, төрлөөр шүүлт хийх боломжтой цахим архив үүсгэнэ.

Арван нэг. Программ хангамж боловсруулах ажлын дараалал

Зам, тээврийн салбарын шагнал олгох үйлчилгээний талаарх судалгааг нэгтгэн авах.

- Системийн дизайн боловсруулах.
- Шагналтай холбоотой мэдээллийн нэгдсэн сан үүсгэх
- Программ хангамжийн хөгжүүлэлт хийх
- Нэвтрүүлэх, тестлэх
- Программын сургалт, танилцуулгыг зохион байгуулах
- Программ ашиглах заавар гарын авлагыг видео, хэвлэмэл байдлаар бэлдэх
- Программыг нэвтрүүлэх

Арван хоёр. Хэрэгжүүлэх хугацаа

Эхлэх хугацаа:	2026 оны 01 дүгээр сарын
Туршилт:	1 сар
Дуусах хугацаа:	2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр

Арван гурав. Программ хангамжийн үр дүн:

13.1. Шагнал олгох, шагналын өргөдөл хүлээн авах, шийдвэрлэх ажлыг хөнгөвчлөх, цаг хугацааг хэмнэх, шагнал олгох үйлчилгээний талаарх тодорхой мэдээлэл авах нөхцөл боломжоор хангагдана.

13.2. Яамны болон салбарын шагнал олгох үйл ажиллагаа нь төрийн өндөр дээд одон, медаль олгох үйл ажиллагаатай уялдаа холбоо бий болно.

13.3. Шагналын материалыг программд оруулж буй байгууллагын төлөөлөгч, ажилтан, албан хаагч, иргэний мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хариуцах тул ажилд хандах хандлага, хариуцлага сайжирна.

ХЯНАСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН
АХЛАХ ШИНЖЭЭЧ

Э.БАДАМСҮРЭН

БОЛОВСРУУЛСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

П.НАСАНЖАРГАЛ

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН
МЭРГЭЖИЛТЭН

Б.ГҮНХИЧЭЭНГҮЙ